



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/543

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 а, 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.2, 11.1.8, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит III хуралдааны 01 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн VI хуралдааны 02 дугаар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 4 дүгээр хуралдааны 3 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрөөс Эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг Орхон аймагт хэрэгжүүлэх дэд хөтөбөрийн 2.4.1.8, "Орхон аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-ны 1.1.11.1 заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд өсвөр үе, хүүхэд залуусыг эрүүл мэндийн боловсролтой, амьдралын зөв дадал хэвшилтэй болгон төлөвшүүлэх, ирээдүйн иргэдийг эрүүл амьдрах чадвартай болгон хүмүүжүүлэхийн тулд ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад эрүүл мэндийн хичээлийг эмч нараар заалгах "Эрүүл мэндийн сургалт" арга хэмжээг "Эрдэнэтийн эмч"ТББ-тай 2017 оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс 4 сарын хугацаанд хамтран зохион байгуулж, төрийн зарим үйлчилгээг гүйцэтгүүлсүгэй.

2.Шаардагдах зардал 9 625 000 /Есөн сая зургаан зуун хорин таван мянган / төгрөгийг "Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулах зардал"-аас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

3.Батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулан, үр дүнг тайлагнаж ажиллахыг "Эрдэнэтийн эмч"ТББ-д, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /н.Бумансор/, Эрүүл мэндийн газар/н.Баттүвшин/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны
09 дүгээр сарын 12-ны өдрийн
57 дугаар захирамжийн хавсралт



Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад эрүүл мэндийн хичээлийг эмч нараар заалгах “Эрүүл мэндийн сургалт” арга хэмжээнд шаардагдах төсөв

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Багшлах эмчийн тоо	Эрүүл мэндийн хичээл орох тоо	Унааны зардал	Нийт
1	Багшлах эмч нарын унааны зардал	125	14	4000	7 000 000
2	Эрүүл мэндийн хичээл заах гарын авлага бэлтгэх	125	14	1500	2 625 000
3	Нийт				9 625 000